



ÀÐÕÀÍ ÃÀÉ ÀÉÌ ÃÈÉÍ  
ÑÒÀÒÈÑÒÈÈÈÉÍ ÕÝÈÕÝÑ

---

# АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2018/01





## ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 111 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 26,6 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 7,1 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 2.1 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98,8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100,0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



Оны эхний 1 сард 174 эхээс 175 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 10,8 хувиар буюу 17 хүүхдээр илүү байна,

Хүн амын нас баралт 41 гарсан нь өнгөрсөн оныхоос 8 тохиолдлоор буюу 24,2 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 1,8 , нас баралт 0,4 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 1,4 промил байна. Төрөхийн улмаас эндсэн эхийн эндэгдэл болон нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

гараагүй, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 5 гарч мянган амьд төрөлтөд 28,6 ногдож байна.

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 5 нь буюу 43 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Эрдэнэбулган(11), Булган (15), Өндөрүлаан (12), сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 44,2 хувь нь салхин цэцгээр, 25,6 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 14,0 хувь нь сүрьеэгээр, 16,2 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс халдварт өвчний гаралт 7,5 хувиар буюу 3 тохиолдлоор өссөн байна.



## АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР

2 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1267 ажилгүй хүн байгаагийн 49,7 хувь нь буюу 630 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10,0 мянган хүн тутамд 218 ажилгүйчүүд

ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 31,2 хувиар багассан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 98,4 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 229 нь дээд, 49 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 898 нь бүрэн болон бүрэн бус дунд, 71 нь бага боловсролтой хүмүүс байна.

1 дүгээр сард ажилгүйчүүдийн бүртгэлд 52 хүн шинээр бүртгүүлж, 402 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болсон байна.



## **НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ**

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 1 сард 3,9 тэрбум төг, зарлага 3,6 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 14,7 сая төг буюу 0,4 хувиар буурч, харин зарлага 160,5 сая төг буюу 4,6 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 14,7 сая төгрөгөөр буурахад тэтгэмжийн даатгалын сангийн орлого 11,1 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 38,5 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 24,8 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 26,9 хувиар тус тус буурсан нь нөлөөлсөн байна.


Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 4,6 хувиар өсөхөд тэтгэврийн, тэтгэмжийн даатгалын сангууд 4,6-75,0 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 3,4 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 113,2 сая төгрөгийг олгосон байна.

Оны эхний 1 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 6,8 мянган хүнд 608,2 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 70,4 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн

тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт 29,6 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 61,1 хувийг халамжийн тэтгэврээр, 28,1 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 10,8 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

**Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр,  
тэтгэмжийн бүтэц**




## ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 14 хүн нэмт хэрэгт холбогдож 48 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 3, өмчлөх эрхийн эсрэг 23, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 4, байгаль хамгаалах журмын эсрэг 1, бусад 17 хэрэг гарсан байна.


Гэмт хэргийн улмаас 2 хүн нас барж, 16 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 98,0 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 6,2 хувийг бүлэглэж 10,4 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 26 хүнийг албадан саатуулж 6 хүнийг баривчилсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 20,0 хувиар буюу 12 тохиолдлоор буурсаны дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 7,7 дахин буюу 20 тохиолдлоор, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 21,7 хувиар буюу 10 тохиолдлоор буурсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 1 сарын байдлаар




## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2018 оны 1 сард аймгийн төсөвт 1907,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 2032,5 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 106,5 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 427,2 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 552,5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 129,1 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг бүх сумд 134,3 хувиас 5,5 дахин биелүүлсэн байна.

### Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл үл хөдлөх хөрөнгийн татвар, газрын төлбөр, ус рашааны төлбөр, төсөвт байгууллагын өөрийн орлогоос бусад нэрийн орлогуудыг 100,0 хувиас 21 дахин биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 72,8 хувийг тусламжийн орлогоор, 20,6 хувийг орлогын албан татвараар, 0,8 хувийг өмчийн татвараар, 0,4 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 2,8 хувийг бусад албан татвараар, 2,6 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна.


Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 26,4 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 37,9 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 0,6 сая төгрөг бүгд 64,9 сая төгрөгийг шилжүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 3234.2 сая төгрөг байгаагийн 55.9 хувийг цалин хөлсөнд, 25.8 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 18.3 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 36,2 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 53,9 хувийг боловсролын салбарт, 8,8 хувийг



эрүүл мэндийн салбарт, 0,7 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0,4 хувийг бусад салбарт зарцууллаа.

### Орон нутгийн төсвийн байгууллагын нийт зарлагын бүтэц, хувиар



### МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 665,0 сая төгрөгийг авч 0,9 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 1 сард банкууд 5,8 мянган иргэд, аж ахуй нэгжид 13,3 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 1 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 24,7 хувиар, олгосон зээлийн хэмжээ 19,0 хувиар өссөн байна. Харин анхаарал хандуулах зээлийн хэмжээ 2,1 дахин, чанаргүй зээлийн хэмжээ 13,0 хувиар нэмэгдсэн байна.



## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2018 оны 1 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0,7 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 5,0 хувиар, 2015 оны 12-р сарынхаас 11,2 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 2017 оны 12 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 214 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 8,7 хувийнх нь өсч, 91,3 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас тараг, сүү, гурилан боов, өөхөн тос, адуу ямааны болон дотор мах, байцаа, лууван, манжин, ногоон цай, угаалгын нунтаг зэргийн үнэ 1,3 – 30,0 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 45,1 хувийнх нь буюу 96 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 54,9 хувийнх нь үнэ тогтвортой байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхээс бүх төрлийн малын мах, хатуу чихэр, цай, давс, тамхи, ундаа, шар, цагаан будаа, алим, элсэн

чихэр, сурагчийн цүнх, сурагчийн дөрвөлжин шугамтай дэвтэр, лаа, трико 4-5 настай охидын, хүүхдийн пүүз, эрэгтэй эмэгтэй хүний гадуур, дотуур хувцас, гутал, ботинк, даавуу, гэр ахуйн хэрэгсэл, тавилга, оо, саван, тамхи, түлшний мод зэрэг барааны үнэ 1,3- 41,2 хувиар нэмэгдсэн байна.




## ХӨДӨӨ АЖ АХУЙ

2 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний мал 99,7 хувиар онд орж оны эхний малын 0,3 хувь буюу 17,8 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 9,3 хувийг адуу, 15,1 хувийг үхэр, 37,5 хувийг хонь, 38,1 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Чулуут, Цахир, Хашаат, Хангай, Ихтамир, Батцэнгэл, Эрдэнэбулган сумдын оны эхний малын 0,5-0,8 хувь нь, бусад сумдын малын 0,1-0,4 хувь нь хорогдсон дүнтэй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



2018 онд манай аймаг ойгоос 96,6 мянган м<sup>3</sup> галын түлээ, 11,1 мянган м<sup>3</sup> хэрэгцээний мод, бүгд 107,7 мянган м<sup>3</sup> мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 1 сард 4,2 мянган м<sup>3</sup> галын түлээ, 0,4 мянган м<sup>3</sup> хэрэгцээний мод, бүгд 4,6

мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 16,7 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.




## АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2018 оны эхний 1 сард оны үнээр 597,5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн оныхоос 0,5 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 212,0 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,6 хувиар бага байна.

Нийт үйлдвэрлэлтийн 8,9 хувийг хүнс ундааны, 0,8 хувийг хэвлэлийн, 68,3 хувийг дулааны эрчим хүчний, 13,3 хувийг усан хангамж, 1,2 хувийг модон эдлэлийн, 7,3 хувийг гутал хувцасны, 0,2 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, хүснэгт маягт, монгол гутал, монгол дээлний үйлдвэрлэл 0,9-123,5 хувиар нэмэгдлээ. Харин бууз, хэрчсэн гурил, гэрийн модог тавилгын үйлдвэрлэлийн хэмжээ 7,7 – 22,2 хувиар буурсан байна.





## ЦАГ УУРЫН БАЙДАЛ

1 дүгээр сард агаарын дундаж температур -9,7-оос -16,2 хэм хүйтэн байсан бөгөөд хамгийн их дулаан Булган, Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг сумдад -1,0-ээс - 4,0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Чулуут, Өндөрүлаан, Өгийнуур, Өлзийт, Батцэнгэл сумдад -40,0-ээс - 44,0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Эрдэнэбулган, Хотонт, Булган, Батцэнгэл, Өлзийт, сумдын нутгаар 6,0- 11,3 мм цас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Хангай, Хайрхан Цахир сумдад 0,9-2,0 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

**Статистикийн хэлтэс**  
**2018.02.13**